МЭДЭЭ · 2025 оны 12-р сарын 9

БУСДАД ДАВУУ БАЙДАЛ БИЙ БОЛГОСОН ХЭРГИЙГ ШҮҮХЭД ШИЛЖҮҮЛЛЭЭ



Прокурорын байгууллага 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 05-ны өдрийг дүүсталх хугацаанд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын 50,074 эрүүгийн хэрэгт хяналт тавин ажиллажээ.

Дээрх хугацаанд 972 гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл бүртгэгдсэн бол хэрэг бүртгэлтийн 746 хэрэг шинээр нээж, 325 хэрэгт прокурор яллах дүгнэлт үйлдсэн байна.

Яллах дүгнэлт үйлдсэн хэргийг тодруулбал, Эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 121, Өмчлөх эрхийн эсрэг 80, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 72, Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 11, Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 9, Авлигын гэмт хэрэг 7, Олон нийтийн аюулгүй байдал ашиг сонирхлын эсрэг, Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг тус бүр 6, Эдийн засгийн гэмт хэрэг 5, Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 4, Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг 2, Соёлын өвийн эсрэг, Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг тус бүр 1 байна.



Нийслэлийн прокурорын газраас яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлсэн зарим хэргээс дурдвал:

- Нийтийн албан тушаалтнаар ажиллаж байсан Б.Д нь бусадтай үгсэн тохиролцож эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийг худалдан авсан мэтээр баримт бүрдүүлэн, өөрийн хамаарал бүхий хүмүүст шилжүүлэх байдлаар өөртөө авсан, худалдан авах гэрээг хуурамчаар үйлдсэн хэрэгт Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 /Эрх мэдэл,албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/, Эрүүгийн хуулийн 18.7 дугаар зүйлийн 1 /Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах/-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхэд,

- Нийтийн албан тушаалтнаар ажиллаж байсан Д.Б нь орон нутагт хийгдэх ажлын төлөвлөгөөнд батлагдаагүй ажлыг хийх гүйцэтгэгчийг сонгохдоо тендер зарлалгүйгээр, нэр бүхий компанийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан тус компанийн дансаар дамжуулан туслан гүйцэтгэгч компанид 178 сая төгрөгийн санхүүжилт олгуулж, бусдад эдийн засгийн давуу байдал бий болгосон хэрэгт Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 /Эрх мэдэл,албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж Завхан аймаг дахь сум дундын анхан шатны шүүхэд,

- Б.Э нар нь нийтийн албан тушаалтнаар ажиллаж байхдаа эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, нэр бүхий иргэнийг ажил үүргээ гүйцэтгээгүй, албан тушаалын тодорхойлолтод заасан ажил үүргээ зохих ёсоор хийж гүйцэтгээгүй болохыг мэдсээр байж цагийн бүртгэл гаргуулан цалин олгож бусдад эдийн засгийн давуу байдал бий болгосон, Д.Б нь нийтийн албан тушаалтнаар томилогдсоноосоо хойш албаны чиг үүргээ хэрэгжүүлэлгүй, өөртөө эдийн засгийн давуу байдал бий

болгох зорилгоор бусдыг гэмт хэрэг үйлдэхэд хүргэн, хууль бусаар нөлөөлж, цагийн бүртгэлийг хуурамчаар гаргуулж, цалин авсан хэрэгт Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 /Эрх мэдэл,албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхэд,

- Д.Б нь нийтийн албан тушаалтнаар ажиллаж байхдаа эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон 500м.кв газрыг албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, бусдын нэр дээр газар эзэмших эрхийн гэрчилгээг гаргаж бусдад давуу байдал бий болгосон хэрэгт Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 /Эрх мэдэл,албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж Дархан-Уул аймаг дахь сум дундын анхан шатны шүүхэд,

-Төрийн өмчит үйлдвэрийн газарт нийтийн албан тушаалтнаар ажиллаж байсан Д.О нь албан үүргээ гүйцэтгэж байхдаа тээврийн хэрэгслийн улсын дугаарын эзэмшигч нараас улсын дугаарыг бусдад шилжүүлэх хүсэлт гаргаагүй байхад зөвшөөрөлгүйгээр хасалт хийж, бусдад давуу байдал бий болгосон хэрэгт Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 /Эрх мэдэл,албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж Дүүргийн эрүү, иргэний хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхэд,

- Л.Ш нь НҮБ-ын 1971 оны “Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай” конвенцын II жагсаалтад багтсан метамфетамины агууламжтай “мөс” гэх нэршилтэй, хориглосон сэтгэцэд нөлөөт бодисыг бусдад худалдсан хэрэгт Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн 2 /Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах/-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж, Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхэд,

- Г.Т нь бусадтай бүлэглэн гадаад улсаас шуудан илгээмж ашиглан НҮБ-ын “Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай” конвенцын II жагсаалтад багтсан “шавар” гэх нэршилтэй сэтгэцэд нөлөөт бодисыг худалдаалах зорилгоор хууль бусаар Монгол Улсад нэвтрүүлж, олж авсан дээрх хэргийг байнга тогтвортой үйлдсэн хэрэгт эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн 1, 3.1, 3.3 дугаар /Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах/-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж,

- Жонш баяжуулах, ашигт малтмал ашиглалт зэргээр үйл ажиллагаа явуулдаг нэр бүхий компани нь жоншны баяжмалын агуулгыг тодорхойлох зорилгоор Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/356/396 хамтарсан тушаалын гуравдугаар хавсралтад заасан "Химийн хорт болон аюултай бодисын ангилалд хамруулсан бодисын жагсаалт"-д багтсан фторт устөрөгчийн хүчил 510 мл хэмжээтэй химийн хорт болон аюултай бодисыг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, ашиг сонирхлын төлөө хууль бусаар ашиглан үйл ажиллагаа явуулсан, хадгалсан хэрэгт Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйлийн 3 /Химийн хорт, аюултай бодисыг хууль бусаар эргэлтэд оруулах/-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж Дорноговь аймаг дахь Сум дундын анхан шатны шүүхэд,

- Нэр бүхий компани нь ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд

ажиллаж, үйл ажиллагаа явуулж байхдаа нүүрсний дээж үзэх зорилгоор Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны А/356/396 дугаар хамтарсан тушаалын гуравдугаар хавсралтад заасан "Химийн хорт болон аюултай бодисын ангилалд хамруулсан бодисын жагсаалт"-д багтсан 500 мл хэмжээтэй цууны хүчил буюу химийн хорт болон аюултай бодисыг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, ашиг сонирхлын төлөө хууль бусаар хадгалсан хэрэгт Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйлийн 3 /Химийн хорт, аюултай бодисыг хууль бусаар эргэлтэд оруулах/-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж Дорноговь аймаг дахь Сум дундын анхан шатны шүүхэд,

-Нэр бүхий компани нь хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө химийн хорт болон аюултай бодисыг ашиглах зөвшөөрөл авалгүйгээр, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/356/396 хамтарсан тушаалын гуравдугаар хавсралтад заасан "Химийн хорт болон аюултай бодисын ангилалд хамруулсан бодисын жагсаалт"-д багтсан натрийн гидроксид бодисыг хаягдал өөх тосыг задлах зорилгоор хууль бусаар ашигласан хэрэгт Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйлийн 3 /Химийн хорт, аюултай бодисыг хууль бусаар эргэлтэд оруулах/-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхэд,

- Ш.М нь согтуугаар тоглоомын талбайд тоглож байсан биеэ хамгаалж чадахгүй бага насны 2 хүүхдийг шалтгаангүйгээр хутгалж, амь биед нь аюултай хүнд гэмтэл учруулан онц харгис хэрцгий аргаар санаатай алахыг завдсан хэрэгт Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 3 /Хүний алах/-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж Дорнод аймаг дахь Сум дундын анхан шатны шүүхэд тус тус шилжүүллээ.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/574